

2

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ӨРНҮҮЛЭГЧ ХЭНТИЙЧҮҮД

● 5860 ИРГЭНД 435.5 ГА ГАЗРЫГ ӨМЧЛҮҮЛЭЭ

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах судалгааг гаргаж орон нутгийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хаягжуулалтын ажлыг 70%-д хүргэж, 2019 оны байдлаар 18 сум газрын үнэлгээний тойрог, газрын төлбөрийн хэмжээг тухайн сумын ИТХ-аараа хэлэлцүүлэн батлуулсан. Улсын чанартай авто зам дагуу Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт нийт 9382 иргэнд 739.37 га газрыг өмчлүүлэх нөөц тогтоогдож, 2019 оны байдлаар өссөн дүнгээр нийт 5860 иргэнд 435.5 га газрыг өмчлүүллээ. Харин Чингис хотод гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр нийтдээ 791 иргэнд 57,1 га газрыг өмчлүүллээ.

Түүнчлэн 2018 онд бүх сумдыг хамруулан зохион байгуулсан "Нээлттэй газрын харилцаа-Орон нутагт" өдөрлөгийн хүрээнд аймгийн хэмжээнд 630 барилга байгууламжийг хувийн хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн бол 2019 онд ОНХС, Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдан барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссод хүлээлгэн өгч буй барилга байгууламжийг хувийн хэрэгжүүллээ.



● БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СОРИЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙГ БАЙГУУЛЛАА

ГХБХБГ-ыг түшиглэн барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг байгуулж, барилгын гүйцэтгэлийн явцад цаг алдалгүй шинжилгээг хийж цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой боллоо. ГХБХБГ-ын Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори нь 2017 онд Барилгын дүүргэгч материалын лабораторийг ашиглалтад оруулсан бол 2018, 2019 онуудад 19 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цемент шинжлэх тоног, төхөөрөмжийг ашиглалтад оруулаад үйл ажиллагааны туршилт явуулан эхэллээ.



● УЛСЫН ТӨСВИЙН 10 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ЗАМ, НОГООН БАЙГУУЛАМЖ, ГЭРЭЛТҮҮЛЭГ ТАВЬЖ БАЙНА

"Манай гудамж-Гэрэлтэй гудамж" дэд хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсвийн 128 сая төгрөгийн хөрөнгөөр Чингис хотын 32 цэгт цамхагт гэрлийг байгуулж, 42 цэгийн камерыг засварлажээ. Улсын төсвийн 10 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 6.7 км хатуу хучилттай авто зам, 27.7



мян.м2 явган хүний зам, 12.8 мян.м2 ногоон байгууламж, 474 гэрэлтүүлэг, орон сууцны байрны доторх зам талбайг шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд Т-170, Т-171, Т-172, Т-173, Т-174, А-25, А-26, А-27, А-33, С-29, С-80, С-78, С-79 орон сууцны байрны доторх зам талбайг шинэчлэх ажил үргэлжилж байна.



● ГЭР ХОРООЛЛЫН ХОТГОР ГҮДГЭРИЙГ ТЭГШИЛЖ, ОРОН СУУЦЫГ ТОХИЖУУЛЛАА

"Мянган нуурын хотгор" дэд хөтөлбөрийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн 230 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн сумын төвийн 1,2,3,4,5 дугаар багуудын гэр хороолол болон орон сууцны нийтийн эзэмшлийн 157.1 га талбайн элэгдэлд өртсөн хотгор, гүдгэрийг тэгшлэх ажлыг гүйцэтгэлээ. ОНХС-ийн 348 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 1,3,4,5-р багуудын орон сууцны дээвэр, орцын засвар, камержуулалт, гадна хашлага хайс зэрэг ажлуудыг гүйцэтгэж ашиглалтад оруулж, иргэдэд амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлжээ.



● ХЭРЛЭН, ЦЭНХЭРМАНДАЛ СУМАНД ҮЕРЭЭС ХАМГААЛАХ БАЙГУУЛАМЖ БАРИГДАНА

Улсын төсвийн 105.3 сая төгрөгийн хөрөнгөөр Чингис хотын үерээс хамгаалах 16 км урттай байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж, зураг төслийг магадлалаар батлуулжээ. 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад Хэрлэн, Цэнхэрмандал сумдын үерээс хамгаалах байгууламжийн ажил тусгагдаад байна.



● ХЭНТИЙ АЙМГИЙН 12 СУМ НЭГДСЭН ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОНО

"Сумын шинэ төв" дэд хөтөлбөрийн хүрээнд Биндэр сумын дэд бүтцийн ажил хийгдэж дууссан бол Улсын болон орон нутгийн төсвийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Адрага, Баян-Овоо, Өмнөдэлгэр сумдын дулааны нэгдсэн шугам сүлжээний ажил дуусаж, бүрэн ашиглалтад орлоо. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Цэнхэрмандал, Жаргалтхаан, Мөрөн, Баянхутаг, Батноров, Дархан, Норовлин сумдад дулааны төвлөрсөн шугам сүлжээ тавих ажлууд үргэлжилж байна. Эдгээр шугам сүлжээний ажлууд ашиглалтад орсноор нийт 18 сумаас 12 нь нэгдсэн дулааны шугам сүлжээнд холбогдож сумын хөгжлийн үндсэн суурь дэд бүтэц бий болох юм. 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 8 сумын инженерийн шугам сүлжээний ажлууд тусгагдан хэрэгжихээр батлагджээ.



● ДУЛААНЫ СТАНЦ ИРЭХ ОНД БАРИГДАНА

Энэ онд Хэрлэн сумын 4-р багт дулааны станцын 2 дугаар хэлхээний шугамын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд 400 м шугамын ажлыг Улсын төсвийн 700 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж ашиглалтад орууллаа. БНСУ-ын зээлийн хөрөнгөөр "Арван аймгийн төвийн



дулааны станц барих төсөл"-ийн ажлын зураг батлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлахад бэлэн болсон. Тендер зарлагдсанаар Ирэх оны хавар барилга угсралтын ажил эхэлнэ. 30 мвт хүчин чадалтай дулааны станц ашиглалтад орсноор 70-80 ажлын байр шинээр нэмэгдэх аж.

● ЧИНГИС ХОТЫН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ИРЭХ ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛНА

Энэ онд улсын төсвийн 904,5 сая төгрөгийн хөрөнгөөр 1987 онд ашиглалтад орсон цэвэр усны төв магистраль 4160 м шугамыг шинэчлэх ажлыг ашиглалтад оруулж, хотын цэвэр усан хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлээ.

Азийн Хөгжлийн Банкны 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингис хотын 3000м³/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг 2019 онд эхлүүлсэн. Ирэх онд барилга угсралтын ажлыг дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа аж.



● 4, 5 ДУГААР БАГИЙН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ ДУЛААНЫ ШУГАМД ХОЛБОВ

2018 онд Хэрлэн сумын 4,5-р багийн Өрхийн эрүүл мэндийн төвийг дулааны шугамд холбох ажлыг ОН-Төсвийн 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, ашиглалтад оруулаад байна.

● ЧИНГИС ХОТ 10 УХААЛАГ ХУДАГТАЙ БОЛЛОО

Чингис хотын ундны усны төвлөрсөн шугамд холбогдоогүй ус түгээх байруудыг төвлөрсөн шугамд холбох ажлын хүрээнд 3-р багийн ус түгээх байрыг төвлөрсөн шугамд холбож, Усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 4-р баг Цацалд ус түгээх байр шинээр барьж ашиглалтад орууллаа. Ингэснээр 2017-2019 онд нийт 10 ус түгээх байранд ухаалаг төхөөрөмж суурилуулж, гэр хорооллын иргэдэд цагийн хязгаарлалтгүйгээр 24 цагаар ундны усыг түгээх боломжтой боллоо.



● 13 СУМДЫН ЦДАШ-ИЙГ ШИНЭЧЛЭВ

Улсын болон орон нутгийн төсөв, төрийн өмчит компаниудын 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 сумдад нийт 92.7 км ЦДАШ-ыг төмөр бетон тулгуур СИП кабелиар шинэчилж, Жаргалтхаан, Бэрх тосгонд дэд станцыг байгуулж иргэд, ААН-ийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг сайжруулсан байна.

● 18 СУМЫН ТӨВ ШИЛЭН КАБЕЛД БҮРЭН ХОЛБОГДЛОО

Чингис хотын гурван байршил дутасгүй интернетийн сүлжээг байгуулж, "Шинэ Өндөрхаан" хорооллын гадна холбоожуулалтын ажлыг ОНХС-ийн 70 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж ашиглалтад оруулсан бол 2019 онд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ий 320 сая төгрөгийн хөрөнгөөр Дадал сум хүртэл 64 км дамжуулах байгууламжийг барих ажлыг хийж гүйцэтгэснээр 18 сумын төв шилэн кабелд бүрэн холбогдлоо.





● **ХЭРЛЭН, БОР-ӨНДӨР СУМ, БЭРХ ТОСГОНЫ ОРОН СУУЦНЫ ФАСАД, ОРЦ, ДЭЭВРИЙГ НЭГ ТЭРБУМ ГАРУЙ ТӨГРӨГӨӨР ЗАСВАРЛАЖЭЭ**

2018-2019 онд улсын төсвийн 640 сая төгрөгийн хөрөнгөөр Бор-Өндөр сум, Бэрх тосгоны орон сууцны байруудын фасад, дээврийн засварыг хийж гүйцэтгэсэн бол ОНХС-ийн 348 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 25 орон сууцны байрны орцын засварын ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулаад байна.



● **УЛСЫН ТӨСВИЙН 650 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ**

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн / банкны байрны/ инженерийн дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчээр Хэнтий-Ус ХХК шалгаран Улсын төсвийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн ажлыг эхлүүлж, ариутгах татуурга, гадна холбоожилт, гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажил хийгдэж дуусан, дулааны болон бохирын усны шугам, өргөх насосын ажлууд хийгдэж байна. Ирэх онд дахин төлөвлөлт хийсэн газар 6 блок бүхий 174 айлын орон сууц баригдаж эхэлнэ.



● **ХУВИЙН ХЭВШИЛ, ОУБ-ЫН САНААЧИЛГААР ХЯМД ӨРТӨГТЭЙ 166 АЙЛЫН ОРОН СУУЦ АШИГЛАЛТАД ОРЖ БАЙНА**

2017 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Шинэ Өндөрхаан хороололд хямд өртөгтэй 48 айлын орон сууцыг, Баян-Овоо сумын төвд хямд өртөгтэй 8 айлын жишиг орон сууцыг 2018 онд "Дэлхийн зөн" ОУБ-ын санал санаачилгаар зорилтот бүлгийн 14 өрхөд дулааны алдагдал багатай хувийн байшинг хашааны хамт тус тус барьж ашиглалтад орууллаа. 2019 онд Чингис хотын 3 байршилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нийт 96 айлын орон сууцны барилга баригдаж эхлээд байна.



● **ШИНЭ ӨНДӨРХААН ХОРООЛОЛ ӨРГӨЖНӨ**

"Шинэ Өндөрхаан" хороололд улсын төсвийн 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 48 айлын орон сууцны барилгын ажил үргэлжилж байна. 2017 онд Шинэ Өндөрхаан хороололд ТОСК-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан 120 айлын орон сууцыг барьж, 120 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулсан.



● ДАДАЛ СУМЫН ГҮҮРИЙГ ЗАСВАРЛАЖ, БАЯН-АДРАГА СУМЫН ОНОН ГОЛД 150 МЕТР УРТТАЙ ТӨМӨР БЕТОН ГҮҮР БАЙГУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Дадал сумын Онон голын 238.9 у/м төмөр бетон гүүрний засварын ажил эхэлсэн бол, Баян-Адарга суманд Онон гол дээгүүр тавигдах 150 метрийн урттай төмөр бетон гүүрийн бүтээн байгуулалтын ажилд улсын төсвийн 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Ган гүүр” ХХК шалгарсан бөгөөд өнгөрсөн 04-р сарын 12-ны өдрөөс бэлтгэл ажлаа хангаж эхэлжээ. Гүүрийг 2020 оны 10-р сарын 31-нд ашиглалтад хүлээлгэж өгөх гэрээг талууд байгуулсан бөгөөд ЗТХЯ захиалагчаар, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аас гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах юм. Үүнчлэн 102 км хатуу хучилттай авто замын ажил, Биндэр сумын Онон голын төмөр бетон гүүрийн ажлууд 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдлаа.



● ЧИНГИС-БЭРХ ЧИГЛЭЛИЙН 20 КМ АВТО ЗАМ АШИГЛАЛТАД ОРЖ, БОР-ӨНДӨР-ДАЛАНЖАРГАЛАН ЧИГЛЭЛИЙН ЗАМЫН СУУРЬ, ДАЛАНГИЙН АЖИЛ ХИЙГДЭВ

Чингис хот-Бэрх чиглэлд шинээр тавигдах хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр “Анандын зам”, “Наранбулаг-Хан” ХХК-иудын түншлэл шалгарч Чингис хотоос Бэрх чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний 20 км замыг 2019 оны 5-р сараас 11-р сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа. Ирэх жил Чингис хот-Бэрх чиглэлийн 70 км авто зам ашиглалтад орно. Мөн энэ жил Бор-Өндөр - Даланжаргалан чиглэлийн 45 км хатуу хучилттай авто замын ажлыг “Билэгт зам” ХХК гүйцэтгэж байна. Замын суурь, далангийн ажлыг хийжээ.



● ХЭНТИЙ АЙМАГТ АВТО БУУДАЛ, ЗҮҮН БҮСИЙН ОНОШИЛГООНЫ ТӨВ АШИГЛАЛТАД ОРЛОО

Хэрлэн сумын 2-р багт орчин үеийн авто буудал, зүүн бүсийн оношилгооны төвийн барилгыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, Орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээг тогтмолжууллаа. Нийтдээ 2,6 тэрбум төгрөгийн өртөгтэй, 2 давхар 1200 м.кв талбайтай томоохон байгууламж баригдсан бөгөөд Зүүн бүсийн гэх тодотголтой энэхүү Авто тээврийн төвийг орон нутгийн “Баялаг Онон” ХХК барьжээ. Нэг давхартаа нийтийн хоолны заал, “Хэнтийд үйлдвэрлэв” брэнд бүтээгдэхүүн сурталчилгааны хэсэг, 2-р давхартаа захиргаа, аж ахуй бүхий цогц байгууламж болсноороо Монгол улсдаа жишиг болохуйц бүтээн байгуулалт хэмээн албаныхан онцолж байна. Тус авто тээврийн төвөөр энгийн өдрүүдэд 400-аад зорчигч үйлчлүүлдэг бөгөөд баяр ёслолын буюу ачаалал ихтэй өдрүүдэд зорчигчдын тоо хоёр дахин нэмэгддэг аж.

Түүнчлэн Чингис хотод зорчигч тээврийн маршрут бий болж, хот хоорондын такси үйлчилгээнд зорчигч тээврийн стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл бүхий 12 жолооч мэргэшсэн зэргийн шалгалтад тэнцэж үйлчилгээ үзүүлж эхэллээ.





● ЧИНГИС ХОТЫН 6 ЧИГЛЭЛД 6 ЭКОБУС ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТОГТМОЛ ЯВЖ БАЙНА

Хэнтий аймаг орон нутагт цахилгаан автобус нэвтрүүлж байгаа хоёр дахь аймаг болж байна. Нийт найман экобус ирсний хоёр нь нөөцөд, зургаа нь Чингис хот доторх зургаан чиглэлийн маршрутаар батлагдсан цагийн хуваарийн дагуу энэ намраас үйлчилгээ үзүүлж эхлээд байна.

Энэ 2019 онд автобусыг улсын төсвийн хөрөнгөөр авах, угсрах, найман экобусны жолооч нарыг сонгон шалгаруулж, үйлдвэр дээр нь автобус угсралт, авто техникийн сургалтад тус тус хамруулжээ. Өнгөрсөн онд улсын төсөвт автобус худалдан авах хөрөнгө сууж, аймгийн ИТХ-аар уг автобусны гражид зориулж 60 сая, нийтийн тээврийн нөхөн олговорт 20 сая төгрөг тусгагдсан байна.

Харин ирэх оны төсөвт нийт 50 автобусны буудлын зураг, төсвийг хийлгүүлэн УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн гэнэ. Хэрэв дэмжигдвэл орчин үеийн шаардлага, хотын өнгө үзэмжид нийцсэн буудлууд баригдсанаар Чингис хотын нийтийн тээврийн үйлчилгээ цогцоороо шийдэгдэх аж.



● ӨНДӨРХААН НИСЭХ БУУДЛЫГ ШИНЭЧИЛЖ, ДАДАЛ СУМАНД “ДЭЛҮҮН БОЛДОГ” НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ БАРИНА

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн 3,5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэхээр шийдвэрлэж, Зам, тээврийн хөгжлийн яаман дээр төслийн нэгж байгуулагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. Дадал суманд Дэлүүн болдог нисэх буудлын барилга 2020 оны улсын төсөвт тусгагдан хэрэгжихээр боллоо.



2.2. БАЯЛАГ БҮТЭЭГЧ ХЭНТИЙЧҮҮД

● ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖЛЭЭ

"Хэнтий аймгийн аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ын дагуу Хэрлэн суманд дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, цэвэр усны үйлдвэр, сүү цагаан идээ боловсруулах буюу "Иштэй ааруул"-ын үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба 4 үйлдвэрийг ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлд хамруулж санхүүжилтийг олгожээ.

● "ХЭНТИЙД ҮЙЛДВЭРЛЭВ" БҮТЭЭГДЭХҮҮН СУРТАЛЧЛАХ ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА

ЖДҮ-ийг дэмжих, байгальд ээлтэй, шинэ технологи бүхий нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний санаачилгыг өрсөлдүүлэн шилдэг брэндийг шалгаруулж дотоод, гадаадын зах зээлд нэвтрүүлэх зорилготой "Хэнтийн брэнд" дэд хөтөлбөрийг 2017 онд батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Хэнтийн брэнд" дэд хөтөлбөрийн хүрээнд "Хэнтийд үйлдвэрлэв" бүтээгдэхүүн сурталчлах төвийг шинээр байгуулан үйлдвэрлэл эрхлэгчдийн нутгийн брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах төвлөрсөн цэгтэй боллоо.

Хэрлэнбаян-Улаан тосгонд Монгол Хунчир брэнд, Баянхутаг суманд ноос, ноолууран бүтээгдэхүүн, Цэнхэрмандал суманд айраг, Хэнтийн Тарвас зэрэг бүтээгдэхүүнүүд шинээр худалдаанд гарч эхэлжээ. Үүнээс Хунчир брэндийг Япон, БНСУ, БНХАУ руу экспортолж байна.

Үүнчлэн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний танилцуулга бүхий "Хэнтийд үйлдвэрлэв танилцуулга ном"-ыг шинээр хэвлүүлэн гаргаж, Аймаг орон нутгийн онцлог шинжийг хадгалсан брэнд бүтээгдэхүүний багцтай болох зорилгоор 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг стандартад нийцсэн сав баглаа боодолтой болгов.

● АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

Сумдын Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд 1,3 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж 400 гаруй иргэнийг түр болон байнгын ажлын байраар хангалаа. 2019 онд ЖДҮДДСанд 1 тэрбум төгрөг хуваарилагдаж 16 төслийг дэмжих шийдвэр гаргаж, 11 төсөлд 651 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон аж.

● ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛЛАА

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэлэг мэдээ мэдээллээр хангах, бизнесийн орчин нөхцөлийг нь сайжруулах, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдаанд гаргах зорилгоор нийт 654 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг 10 удаагийн сургалт арга хэмжээнд хамруулжээ. 2017-2019 ХАҮТанхимтай хамтран 70 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, бизнес эрхлэгчдийг ӨМӨЗО болон ОХУ-д зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд оролцуулж ажиллаа.





● ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ 77 ХУВИЙГ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ХАНГАЖ ЭХЭЛЛЭЭ

2017-2019 онд ерөнхий боловсролын 26 сургууль, 32 цэцэрлэгт нийт 4.7 тэрбум төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг хийж, нийт хүнсний бүтээгдэхүүний 77 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангаж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төвүүдээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалж хэвшсэн төдийгүй "Хэнтийд үйлдвэрлэв" нэрийн барааны дэлгүүр 2019 оны 07 сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж 15 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Шинээр бизнес эрхлэх санал санаачилга гаргасан 3 үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрийн байраар хангаж, 2019 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн гарааны 10 үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэвлэл мэдээллийн байгууллагаар сурталчилж ажиллав.

● 10 СУМАНД ШИНЭЭР АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАРИЛАА


Сум бүрт ахуйн үйлчилгээний төвтэй болох зорилго тавин орон нутгийн төсвийн хөрөнгө болон сумдын Сум хөгжүүлэх сан, төсөл хөтөлбөр, Олон улсын байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгээр нийт 10 суманд ахуйн үйлчилгээний төв шинээр байгуулж оёдолчин, үсчин, цахилгаан засварчин, уран дархан гэх мэт 50 гаруй иргэнийг ажлын байртай болгожээ.

● БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛЖ, 8 ҮЙЛДВЭРИЙГ ҮЙЛДВЭРИЙН БАЙРААР ХАНГАЛАА

Орон нутагтаа ЖДҮ-ийг хөгжүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор МСҮТ-ийн хуучин байрыг цэвэр, бохир ус, дулаанаар хангах асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэн Бизнес инкубатор төвийг байгуулж, 8 үйлдвэрийг үйлдвэрийн байраар хангаж, 25 иргэнийг байнгын ажлын байртай болголоо.

● 64 ХОРШООНЫ ГИШҮҮН АЖЛЫН БАЙРТАЙ БОЛЖЭЭ

Хоршоог хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 13 дугаар тогтоолоор батлуулан "Хоршоо, хоршооны засаглал", "Хоршооны маркетингийг хөгжүүлэх, бизнес төлөвлөлт" зэрэг шаталсан сургалт, хоршоологчдын зөвлөгөөнд нийт 200, гадаад дотоодын туршлага судлах зөвлөгөөнд 45 хоршооны төлөөллийг оролцуулж мэдлэг, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Тухайлбал, хоршооны үйл ажиллагаа идэвхжиж, бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжсөнтэй холбоотойгоор шинээр 64 хоршооны гишүүн ажлын байртай болж, Сумдын Сум хөгжүүлэх сан болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 12 хоршоо 60,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдаж үйл ажиллагаагаа өргөжүүллээ.



2.3. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

● “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 360 ААН-Д ХЯНАЛТ ТАВЬЖ, 15 ТӨРЛИЙН ЗӨВЛӨМЖ, СЭРЭМЖЛҮҮЛГИЙГ ХҮРГЭЖЭЭ

Хүнсний тухай хуульд "Хүнсний аюулгүй байдал гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг хэлнэ" гэж тодорхойлсон байдаг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас боловсруулсан "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тэгвэл Хэнтий аймаг тус хөтөлбөрийн хүрээнд 360 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, 15 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг хүргэж, 17000 иргэний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгууллаа.



● 7 СУМЫН 10 ӨРХ ХОНИНЫ НЭХИЙ ЭЛДЭХ АНХАН ШАТНЫ ЦЕХ БАЙГУУЛЛАА

Аймгийн ЖДҮД-Дэд сангаас Малын гаралтай дайвар бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахаар санал санаачилга гаргасан 1 аж ахуйн нэгж, 1 иргэнийг 204,6 сая төгрөгөөр дэмжиж ажиллав. Тус үйлдвэр үйл ажиллагаа явуулж эхэлснээр 31 иргэн ажлын байраар хангагдах боломж бүрджээ. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сумдын СХСангаас 60 гаруй сая төгрөгийн санхүүжилт олгож 7 сумын 10 өрх хонины нэхий элдэх анхан шатны цех байгуулж, үйл ажиллагаагаа явуулж нийт 40 ажлын байр бий болоод байна.



● СҮҮЛИЙН ГУРВАН ЖИЛД “ЦАГААН САР-ЦАГААН ИДЭЭ”, НАМРЫН БАЯР” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГААР 932,4 САЯ ТӨГРӨГИЙН БОРЛУУЛАЛТ ХИЙВ

Аймгийн Хөдөө аж ахуйн мэргэжилтний сургалт, зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, 2017-2019 онд 425 мэргэжилтэн, тариаланчид, ногоочдын сургалт, зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж нийт 600 гаруй ногоочид тариаланчдыг хамруулжээ. Үүнчлэн анх удаа Аймгийн тариаланчид ногоочдын нэгдсэн зөвлөгөөн, МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор Хэнтий аймгийн ногоочдын зөвлөгөөн зохион байгуулж, нийт 250 тариаланч, ногоочдыг хамруулан сургалт мэдээлэл өгч, бизнест нь дэмжлэг үзүүлэхээр болжээ.



2017-2019 онуудад “Цагаан сар-Цагаан идээ”, Намрын баяр” үзэсгэлэн худалдаанд оролцогчдын тоо, борлуулалтын орлого тогтмол өсөж, 18 сум, нэг тосгоны 1360 үйлдвэрлэгчид оролцож, нийт 932.4 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

● МАЛЫН ҮҮЛДЭР ОМОГ, ТАВААРЛАГ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛСНЭЭР МАЛЧДЫН ОРЛОГО НЭМЭГДЛЭЭ

2017-2019 онд аймгийн мал сүргийн бүтцэд судалгаа хийж, тохироогоор дутагдаж буй бухыг 1100 толгой буюу 33.0 хувь, хуцыг 5867 толгой буюу 28 хувь, ухныг 4585 толгой буюу 28 хувиар тус



тус нэмэгдүүлж, Малын үүлдэр омог, таваарлаг байдлыг нэмэгдүүлэх зорилгоор сайн чанарын хээлтүүлэгч худалдан авч малчдад өгснөөр малчдын малаас олох ашиг орлого нэмэгдэх боломж бүрдэж байна.

Тухайлбал, "Тал нутгийн цагаан" үүлдрийн хонины чанарыг сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 7,0 сая төгрөгийн хөрөнгөөр "Орхон" үүлдрийн 6 толгой шилмэл хээлтүүлэгч, 20 хээлтэгч худалдан авсан. 29.5 мянган ямаанд үзлэг ангилалт хийж, ноолуурын чанар гарц сайтай Галшарын улаан ямааг шилмэл "Омог"-оор баталгаажуулжээ. Дадал, Биндэр, Батширээт, Баян-Адарга, Норовлин сумдын 5.0 мянган үхэр, нийт 14.0 сая төгрөгөөр 14.9 мянган үхэрт ангилалт хийж, 35.7 хувь болох 5315 толгой үхрийг цөм сүрэгт бүртгэсэн.

Мөн Батноров сумын "Сүүний чиглэлийн үхэр үржүүлэх, сүү, цагаан идээ боловсруулах" төсөл, Биндэр сумын "Тод-Өндөр" ХХК-ийн "Махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэх" төслийн дэмжиж аймгийн ЖДҮДД-Сангаас тус тус 50.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлжээ.



● МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧИН 99.9 ХУВИАР БУУРЧЭЭ

Ариутгал халдваргүйжилтийн ажлыг жил бүр зохион байгуулж давхардсан тоогоор халдварт өвчний 820 гаруй голомт, 141.3 мянган м2 талбайг халдваргүйжүүлснээр малын гоц халдварт өвчин 99.9 хувь буурч, халдварт өвчний гаралт 70 гаруй хувиар буурчээ.



● 8 СУМАНД МАЛ ЭМНЭЛГИЙН НЭГДСЭН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛЛАА

2017-2019 онуудад нийт 8 суманд мал эмнэлгийн нэгдсэн лаборатори буюу нэг цэгийн үйлчилгээний төв бий болсноор малчдад түргэн шуурхай үйлчилж малын гаралтай бүтээгдэхүүнд лабораторийн анхан шатны шинжилгээ хийж хэвшээд байна.



● ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛЭГ ХИЙЖ ХЭВШЛЭЭ

2017-2019 онд 272 үхэрт герефорт болон хар тарлан үүлдрийн бух, 1780 хонинд эдельба үүлдрийн хуц, 1806 толгой ямаанд нутгийн шилмэл үүлдрийн ухнын үрээр нийт 3858 хээлтэгчид зохиомол хээлтүүлэг хийж малын чанар, таваарлаг байдлыг нэмэгдүүлэхэд анхаарчээ.

Малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдийг бэлтгэх, мал үржлийн аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх дэвшилтэт арга, туршлагыг судлахад нийт 710 гаруй ажилтан албан хаагч, малчдыг сургалт зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнд хамруулав.



● 162 ХУДАГ ШИНЭЭР ГАРГАЛАА

2017-2019 онд бэлчээрийн усан хангамжид зориулан улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 65, энгийн уурхайн 97 нийт 162 худаг шинээр гаргаж, 372.5 мянган га бэлчээрийн талбайг усжуулж, аймгийн хэмжээнд 1610 бэлчээрийн зориулалттай худагтай боллоо. Батноров



суманд 682.5 мянган төгрөгийн хөрөнгөөр 10000 м.куб эзлэхүүнтэй "Ардын хөв", Өмнөдэлгэр суманд улсын төсвийн 165,0 сая төгрөгийн хөрөнгөөр 37264 м3 эзлэхүүнтэй "Хөв, цөөрөм" байгууллаа.

● НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР...

- 2017-2019 онд нийт 3.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт 40 аж ахуйн нэгж хамрагдсан дүн гарлаа.
- Мөрөн суманд дунд оврын трактор иж бүрдлийн хамт 2 ш, 5 ш хүлэмж, гүн өрмийн худаг нэгийг гаргаж нийт 189.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.
- Улсын төсвийн 263,5 сая төгрөгийн хөрөнгөөр үлийн цагаан оготно устгалын ажлыг хийж 154.0 мянган га бэлчээрийг хамгааллаа.



● ХЭНТИЙ АЙМАГ ТӨМС ХҮНСНИЙ НОГООНЫ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНИЙХЭЭ 70 ХУВИЙГ ХАНГАЖ БАЙНА

2017-2019 онд Хэнтий аймаг 4947.5 га атаршсан тариалангийн талбайг нэмж эргэлтэд оруулж, 9 сумын 16 багийг 94.2 мянган га талбайг тариалангийн бүс нутаг болгон зарласан. Тэгвэл 2019 онд нийт 19,2 мянган га-д тариалалт хийж үүнээс үр тариа 12,2 га-д тариалж 13,4 мянган тн буюу нэгжээс 12,2 цн, төмс хүнсний ногоо нийт 368 га-д тариалж 5347,7 тн буюу нэгжээс 145 цн тус тус хураан авсан нь төмс хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээ 90 хувь, хураан авсан ургац 16.4 хувиар тус тус нэмэгджээ. Төмс хүнсний ногооны дотоодын хэрэглээг 70 хувь хангаж байгаа нь 2016 оны мөн үеийнхтэй харьцуулахад 50 хувиар нэмэгдсэн дүн гарчээ.



● 61 ХҮЛЭМЖ, 390 ТОННЫН БАГТААМЖТАЙ 9 ЗООРЬ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРЖЭЭ

Жаргалтхаан суманд Солонгос улсын хөрөнгө оруулалтаар 10*6 хэмжээтэй өвлийн хүлэмж барьж ашиглалтад оруулсан бол энэ онд Баян-Адарга, Мөрөн, Батширээт, Баян-Овоо, Бор-Өндөр, Дархан, Биндэр, Хурх, Дадал, Хэрлэн, Өмнөдэлгэр зэрэг сумдад ОНХС, Дэлхийн зөн, ХХААҮХЯмны хөнгөлөлттэй дэмжлэгт хамрагдаж нийт 4672 м.кв 61 хүлэмж нэмэгдсэн байна.

Харин 2017-2019 онд 5 суманд 210 тн-ын багтаамжтай 6 зоорь, 100 тн-ын багтаамжтай 3 зоорь, нийт 390 тн багтаамжтай 9 зоорь ашиглалтад орлоо.



● ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЛЭН, МӨРӨН СУМДЫН НОГООЧДОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

ХХААҮХЯ-аас Мөрөн, Хэрлэн суманд дунд оврын трактор 2 ш дагалдах хэрэгслийн хамт, усалгааны систем, хүлэмж нийт 174.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг данснаас шууд шилжүүлэн олгосон бол МУ-ын Ерөнхий сайд албан айлчлалын үеэрээ Хэрлэн, Мөрөн сумын ногоочдод 187.7 сая төгрөгийн дундын тоног төхөөрөмжийг гардуулжээ.

Монгол улсын ЗГ-аас батлагдсан "Жимс, жимсгэнэ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 3000 ш алимны суулгацыг 2 га талбайд, алим, чавганы 100 ш, үхрийн нүд 162ш, чацаргана 20ш, интоор-20ш тус тус нэмж тариалаад байна.





ХЭНТИЙ АЙМАГ “ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ” БОЛНО

Хэнтий аймагт Улсын төсвийн 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Биндэр суманд Их Монгол Улс, Монголын эзэнт гүрэн, Батноров суманд “Хүлэгбаатар Боорчи-Андлалын өргөө”, Хэнтий аймгийн Норовлин суманд “Шихихутаг нууц товчоо” түүхэн аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах ажлыг эхлүүлсэн. Эдгээр цогцолборууд ирэх жил ашиглалтад орж жуулчдаа хүлээн авах төлөвлөгөөтэй барилгын ажлууд нь амжилттай үргэлжилж байна. Үүгээр зогсохгүй Чингис хааны төрсөн нутаг Хэнтий аймгийн Дадал сумын нутагт “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” төслийг 19 сая амдоллараар барих ажлыг өнгөрсөн намраас эхлүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар “Түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилт дэвшүүлж, 2020 он гэхэд Монголд аялах гадаадын жуулчдын тоог 1 саяд хүргэх, салбарын орлогыг 1,1 тэрбум ам.доллар буюу 2,8 их наяд төгрөгт хүргэхээр томоохон төслүүдийг эхлүүлэн ажиллаж байгаа. Иймээс зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх, тэр дундаа Их эзэн Чингис хааны төрсөн нутаг Хэнтий аймагт орших түүхэн газар нутгууд руу жуулчдыг татах зорилгоор бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг өнгөрсөн оноос эхлүүлсэн нь ажил хэрэг болж байна.

